



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 1509

Алтай хот


Гамшгаас хамгаалах иж бүрэн, команд штабын сургууль, бэлэн байдлын үзлэг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2 дахь хэсэг, аймгийн Засаг дарга, Шадар сайдтай байгуулсан гэрээний 3.8 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Гамшгаас хамгаалах иж бүрэн, команд штабын дадлага, сургуулийг цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан 11 дүгээр сарын 08-наас 11 дүгээр сарын 20-ны хооронд зохион байгуулсугай.

2. Гамшгаас хамгаалах иж бүрэн, команд штабын сургууль, Засаг даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэг зохион байгуулах сумдын нэrsийг нэгдүгээр хавсралтаар, ажлын хэсгийг хоёрдугаар хасралтаар тус тус баталсугай.

3. Гамшгаас хамгаалах иж бүрэн, команд штабын сургуулийг чанартай зохион байгуулж, үр дүng илтгэх хуудсаар танилцуулахыг Онцгой байдлын газар (хошууч Л.Баянбаатар)-т үүрэг болгосугай.



Аймгийн Засаг даргын 20¹¹ оны
дугаар сарын 09⁰⁹ны өдрийн 15¹⁵ дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

ГАМШГАС ХАМГААЛАХ ИЖ БҮРЭН КОМАНД ШТАБЫН
ДАДЛАГА, СУРГУУЛЬ, БЭЛЭН БАЙДЛЫН ҮЗЛЭГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ СУМДЫН НЭРС

Д/д	Дадлага, сургуулийн нэрс	Зохион байгуулагдах сум
1	Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль	Бугат сум
		Цогт сум
		Тонхил сум
2	Гамшгаас хамгаалах команд штабын сургууль	Цээл сум
		Хөхморьт сум
		Баянтоорой тосгон
3	Засаг даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэг	Бигэр сум
		Халиун сум
		Шарга сум
		Төгрөг сум
		Дарив сум
		Баян-Уул сум

—оOо—

Аймгийн Засаг даргын 20¹¹ оны
дугаар сарын 08-ны өдрийн 16:09 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ДСА0042

- Сургуулийн удирдагч: Л.Баянбаатар - (Онцгой байдлын газрын дарга, хошууч)
- Штабын дарга: Т.Баттүвшин - (Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, дэд хурандаа)
- Гишүүд:
Ц.Амарсанаа - (Гал түймрийн улсын хяналтын байцаагч, хошууч)
Б.Батдорж - (Ангиллын сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн, ахмад)
Т.Ууганжаргал - (Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, дэслэгч)
Д.Болор-Эрдэнэ- (Эмч, сэтгэл зүйч, дэслэгч)
Э.Мөнхбаатар - (Шуурхай албаны жолооч, ахлах ахлагч)
А.Цагаандархи - (Улаан загалмайн хорооны арга зүйч)

—oOo—